

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

|   |    |
|---|----|
| 1. Аудитын гэрчилгээ .....  | 3  |
| 2. Аудитын тайлан.....  | 5  |
| 2.1. Оршил .....  | 5  |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....  | 5  |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....   | 5  |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....   | 6  |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 6  |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....  | 7  |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....   | 7  |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....  | 7  |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....   | 8  |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....  | 9  |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл.....  | 9  |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....   | 9  |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....  | 9  |
| 3. Менежментийн захидал .....   | 10 |
| Аудит хийсэн санхүүгийн тайлан.....   | 13 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....   | 13 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....  | 15 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....   | 17 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....   | 20 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....   | 21 |
| 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....   | 23 |

## Товчилсонүгийнжагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |
| БХЯ      | Батлан хамгаалах яам  |
| БСШУСЯ   | Боловсрол, соёл шинжлэх ухааны яам                          |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                                       |
| САГ      | Санхүүгийн аудитын газар                                    |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                                 |
| НББББ    | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг              |
| НББ      | Нягтлан бодох бүртгэл                                       |
| НӨАТ     | Нэмэгдсэн өртгийн албан татвар                              |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙН  
ЗАХИРАЛ ДЭД ХУРАНДАА  
Д.ГАНЗОРИГ ТАНАА

2020.03.09 № 06/757  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Монгол цэргийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Ганзориг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн дотоод хяналт, зардал, нягтлан бодох бүртгэл, НБББББ-тэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол цэргийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол цэргийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 02-ноос 2020 оны 02 дугаар сарын 14-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газартай байгуулсан гурвалсан гэрээний дагуу “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн анхан шатны чанарын хяналт хэрэгжүүлэхээр захирал Ж.Цэцэгмаа, аудитыг хийж гүйцэтгэхээр ахлах аудитор Б.Мягмар, аудиторын туслах Г.Ундармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол цэргийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АОУС, АДБОУС, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Монгол цэргийн музейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол төр, ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө баатарлаг гавъяа байгуулсан үе үеийн эрэлхэг хөвгүүдийн тэмцлийн яндашгүй түүхийг ард иргэдэд таниулах, цэргийн түүхэнд холбогдох эд өлгийн хайгуул, судалгаа хийж, сурвалжлан олох, хадгалж хамгаалах, судлах, дэлгэн үзүүлэх, Монголын төрийн батлан хамгаалах бодлого шийдвэрийг сурталчлан таниулахад оршино.

2019 онд Монгол цэргийн музей нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнагдсан байна.

### **Монгол цэргийн музейн үйл ажиллагааны чиглэл нь:**

Олон нийтэд Монгол газар шороо, төрийн тусгаар тогтнол, эрх чөлөө, бүрэн бүтэн байдлын төлөө үе үеийнхний хийсэн баатарлаг тэмцэл, аугаа ялалтуудын үнэ цэнэ, алдар гавьяаг мөнхөлж, тэднийг эх орноо хайрлах, баатарлаг түүх, дайчин уламжлалаараа бахархах үзлээр хүмүүжүүлэх зорилгоор нийгэмд үйлчилж, монгол цэргийн түүхийг судлах, түүнд холбогдох археологийн хайгуул, малтлага хийх, эд өлгийн зүйлийн цуглуулга, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, сурталчилгааг зохион байгуулах ашгийн төлөө бус олон нийтэд нээлттэй үйлчлэх явдал юм.

2019 оноос Ерөнхий боловсролын бүх сургуулиудын сургалтын хөтөлбөрт Монгол цэргийн музейг үнэ төлбөргүй үзүүлэх, сурталчилах, зэрэг хөтөлбөр заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 тоот “Журам батлах тухай” тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 тоот “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 тоот “Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн өөрчлөлт;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Монгол цэргийн музейн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Гэвч энэ нь Батлан хамгаалах яамны хэмжээнд хийгдсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгаа бөгөөд Монгол цэргийн музейн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон бодлого журам боловсруулан мөрдөх шаардлагатай байна.

Монгол цэргийн музей ньсанхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous 3.0” программ хангамж ашигладаг байна.

Монгол цэргийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол цэргийн музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд бэрсдэлтэй асуудалд бгорим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийнсанхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 534,224.3мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 10,684.5мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 532,396.5 мянган төгрөгнөөс 2 хувиартооцон10,647.9мянган төгрөгөөр тодорхойлсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол цэргийн музейн2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,226.4 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь:авлага, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | /мянган төгрөг/   |
|---|--------------------|--------------------|-------------------|
|   |                    |                    | Өөрчлөлт          |
| Б   | 1                  | 2                  | 3=2-1             |
| Мөнгөн хөрөнгө                                    | -                  | -                  | -                 |
| Авлага  | 2,538.4            | -                  | (2,538.4)         |
| Урьдчилгаа  | 92.1               | -                  | (92.1)            |
| Бараа материал                                    | 34,862.7           | 34,312.0           | (550.7)           |
| Үндсэн хөрөнгө                                    | 5,289,779.8        | 5,235,734.6        | (54,045.2)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>5,327,273.1</b> | <b>5,270,046.7</b> | <b>(57,226.4)</b> |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 5,327,273.1        | 5,270,046,7        | <b>(57,226.4)</b> |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | 5,327,273.1        | 5,270,046,7        | <b>(57,226.4)</b> |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь түүх соёлын үнэт үзмэрийг 2015 онд хулгайд алдсан бөгөөд асуудлыг 3 жил шүүх хуулийн байгууллагаар шийдвэр гаргуулахаар хөөцөлдөөд 2018 онд шийдвэр гаргуулан эзэн холбогдогчийг тогтоолгон өр төлбөрийг 2019 онд бүрэн барагдуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансанд хөрөнгө оруулалтаар барилга байгууламж, дулааны шугам сүлжээнд их засвар хийх, тавилга хэрэгсэл, түүх соёлын дурсгалт зүйл, программ хангамж шинээр авч үндсэн хөрөнгийг сайжруулсан болон нэмэгдүүлсэн. Тухайлбал

- БХЯ-ны сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/376 тоот тушаалаар шаардлага хангахгүй болсон 4,118.1 мянган төгрөгний үндсэн хөрөнгийг данснаас хасаж, Монгол цэргийн музейн барилга байгууламжийн дулааны шугамыг 18,038.8 мянган төгрөгөөр их засвар хийж үндсэн хөрөнгө капиталжуулсан байна.
- БСШУСЯ-ны соёл урлагийн газраас түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах ажлын хүрээнд 12,300.0 мянган төгрөгний санхүүгийн тусламж үзүүлэн зураг өлгөх нягтруулсан өлгүүр, шургуулгатай хадгалалт, хамгаалалтын шүүгээг зохиох журмын дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж эд хогшил дансанд бүртгэж авсан байна.
- 2019 онд үндсэн хөрөнгийн дансанд хөрөнгийн тусгай дансанд бүртгэлтэй байсан 6,394.8 мянган төгрөгийн түүх соёлын эд өлгийн зүйлийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэж авсан байна.
- Биет бус хөрөнгө өссөн шалтгаан нь хүний нөөцийн албанд “агм” нэртэй архив бичиг хэргийн программ хангамж 350.0 мянган төгрөгөөр худалдан авч нэмэгдүүлсэн.

2019 онд 90,571.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсан. Мөн хасагдсан хөрөнгийн элэгдэл 3,560.5 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгө данс нь 54,045.2 мянган төгрөгөөр буурсан нь байгуулсан харимтлагдсан элэгдэлтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,270,046.7 мянган төгрөг болж 57,226.4 мянган төгрөгөөр буурсан нь 2019 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалсан байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 451,290.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 450,861.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

Нийт зардлын 409,420.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 10,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр батлагдаж, зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2019 онд Монгол цэргийн музей нь өөрийн үйл ажиллагаанаас нийт 11,842.8 мянган төгрөгний орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- Үзвэрийн билетийн борлуулалтаас 5,407.7 мянган төгрөг;
- Түрээсийн орлого 6,435.1 мянган төгрөг;

Нэмэлт санхүүжилт дансанд 31,869.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнд:



- БХЯ-наас авсан 18,038.8 мянган төгрөг;
- БСШУСЯ-наас хандив тусламжаар 12,000.0 мянган төгрөг;
- Дээд шатны төсвийн захирагчаас 1,831.1 мянган төгрөг;

#### **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон бэрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл шинээр нэмж тодорхойлон нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 8,358.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,538.4 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн орлогыг данс бүртгэлд 2,538.4 мянган төгрөгөөр дутуу тусгасан байсныг залруулсан.

Аудитаар илэрсэн 5,820.0 мянган төгрөгний зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татах асуудал байхгүй.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Монгол цэргийн музей нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “шилэн дансны мэдээлэл”-дзаасны дагуу150мэдээллийг бүрэн гүйцэт байршуулсан байна.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,542.0мянган төгрөгийн зөрчилд3 зөвлөмж өгснийг бүрэнхэрэгжүүлсэн байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монгол цэргийн музейн2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитоор илэрсэн залруулагдаагүй 5,820.0 мянган төгрөгний алдаа зөрчил нь бидний тогтоосон 10,647.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Монгол цэргийн музейн2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал**

3.1.1 Илрүүлэлт: Батлан хамгаалах салбарын хэмжээнд мөрддөг НБББББ байгаа боловч Монгол цэргийн музейн үйл ажиллагааны онцлогт тохирсон зарим зүйл заалтууд байхгүй байна. Үүнд: Батлан хамгаалах салбарын НБББББ-ийн 4 дүгээр зүйл Бараа материалын бүртгэлийн бодлого, зарчим

- 4.6.4 үндсэн хөрөнгийн үнэлгээ хэсэгт түүх соёлын эд өлгийн зүйлийг хэн, хэзээ хэрхэн үнэлэх заалт байхгүй.
- 4.6.6 үндсэн хөрөнгийн элэгдэлд түүх соёлын эд өлгийн зүйлийг элэгдэл, сэргээн засварлахыг хэрхэн бүртгэж тайлагнах талаар тусгагдаагүй. Мөн түүх соёлын эд өлгийн зүйлийн тусгай бүртгэлд ямар эд өлгийн зүйлийг бүртгэх, хэзээ үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэх талаар тусгагдаагүй байна.

3.1.2 Эрсдэл: Бүртгэл тайлан алдаатай илэрхийлэгдэх эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Зөвлөмжийг хэрэгжүүлж өөрийн онцлогт тохирсон зүйл заалтыг НБББББ-д нэмж оруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### **3.2 Зардлын данстай холбоотой асуудал**

3.2.1 Илрүүлэлт: Монгол цэргийн музейн нь 120.0 мянган төгрөгийн бичиг хэрэг худалдан авахдаа И-баримт бүрдүүлээгүй.

3.2.2 Эрсдэл: Тайлант хугацаанд цахим И-баримтын бүрдэлийг ханган ажиллаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13 заалтыг зөрчсөн байна.

- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Бараа материал худалдан авахдаа НББ-ийн тухай хуулийн 13.7, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-ыг үндэслэн зардлын баримтыг И-баримтаар баталгаажуулах.
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.
- 3.2.5 Илрүүлэлт: Монгол цэргийн музей нь 2019 оны эхний хагас жилд ажиллагсдын цалин хөлсийг 3,200.0 мянган төгрөгөөр төсөвт тусгаагүй байхад нэмэгдүүлж олгон өглөг үүсгэсэн.
- 3.2.6 Эрсдэл: Улсын төсвийг үр ашиггүй, хяналтгүй зарцуулах эрсдэлтэй.
- 3.2.7 Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд цалин хөлсийг олгож байх.
- 3.2.8 Байгууллагаас өгсөн хариу: 2019 оны жилийн эцсээр БХЯ-наасцалингийн төсвийг нэмэгдүүлэн батлуулсан болно. Цаашид анхаарч ажиллана.
- 3.2.9 Илрүүлэлт: Монгол цэргийн музейн үндсэн хөрөнгөд автомашин бүртгэлгүй, төсөвт батлагдсан автомашин ашиглах зөвшөөрөл, эрхгүй байж тээврийн шатахууны зардал 2,500.0 мянган төгрөг гаргасан.
- 3.2.10 Эрсдэл: Улсын төсвийг үр ашиггүй, хяналтгүй зарцуулах эрсдэлтэй.
- 3.2.11 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын тогтоол суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай 266 дугаар тушаалын дагуу захирал нь суудлын автомашин хэрэглэхгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.
- 3.2.12 Байгууллагаас өгсөн хариу: 2019 оны жилийн эцсээр БХЯ-наас суудлын автомашинаар нөхөн хангагдах хүртэл хугацаанд батлагдсан төсвийн хүрээнд албан хэрэгцээндээ автомашин ашиглах гэрээ байгуулан, холбогдох журмын дагуу шатахуун зарцуулалт хийж ажиллахыг зөвшөөрсөн албан бичиг гаргуулан авсан.

### **3.3 Дотоод хяналттай холбоотой асуудал**

- 3.3.1 Илрүүлэлт: Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй дотоод хяналтын нэгж нь 2019 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар 2019 онд хийсэн ажлынхаа тайланг гаргаагүй байсан.
- 3.3.2 Эрсдэл: Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд тавих дотоод хяналт сул байвал хөрөнгө үрэгдэх, хөрөнгө хулгайд алдагдах эрсдэлтэй.
- 3.3.3 Өгсөн зөвлөмж: Түүх соёлын эд өлгийн зүйлийн хадгалалт, хамгаалалт хариуцан ажиллаж байгаа ажиллагсдад хяналт тавих зорилгоор дотоод хяналтын нэгж нь эд өлгийн зүйл, хөрөнгө хүлээлцэх бүртгэл өдөр болгон хөтлөж хэвших, дотоод хяналтын ажлын тайланд тусгаж өгөх.
- 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу: Цаашид анхаарч зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

### **3.4 Балансын данстай холбоотой асуудал**

- 3.4.1 Илрүүлэлт Төсөвт байгууллагын өөрийн орлого, нэмэлт санхүүжилтийн дансыг төрийн сантай тооцоо нийлсэн байдлаар зөв ангилаж, данс бүртгэлд тусгаж хэвшээгүй.
- 3.4.2 Эрсдэл: Төсвийн зарцуулалтын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт санхүүжилтийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

3.4.3 Өгсөн зөвлөмж: Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлагыг төрийн сантай тооцоо нийлж актаар баталгаажуулж байх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу: Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгагавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код  | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл                 | Эцсийн үлдэгдэл                |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b><u>37,493,275.35</u></b>    | <b><u>34,312,046.35</u></b>    |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>   | 00.00                          | 00.00                          |
| <b>32</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>                               | 00.00                          | 00.00                          |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>   | 2,538,400.00                   | 00.00                          |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>   | 2,538,400.00                   | 00.00                          |
| 3351        | Байгууллагаас авах авлага   | 00.00                          | 00.00                          |
| 3352        | Хувь хүмүүсээс авах авлага  | 2,538,400.00                   | 00.00                          |
| <b>34</b>   | <b>УРЬДЧИЛГАА</b>   | 92,101.00                      | 00.00                          |
| 34600       | Урьдчилж гарсан зардал  | 92,101.00                      | 00.00                          |
| <b>3471</b> | <b>Урьдчилгаа тооцоо</b>  | 00.00                          | 00.00                          |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 34,862,774.35                  | 34,312,046.35                  |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>  | 34,862,774.35                  | 34,312,046.35                  |
| 35410       | Бичиг хэргийн материал  | 2,365,408.38                   | 1,855,889.00                   |
| 35420       | Аж ахуйн материал   | 2,525,180.00                   | 2,508,480.00                   |
| 35450       | Барилгын засварын материал  | 5,044,260.00                   | 5,040,200.00                   |
| 35470       | Бусад хангамжийн материал   | 24,927,925.97                  | 24,907,477.35                  |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b><u>5,289,779,803.52</u></b> | <b><u>5,235,734,641.51</u></b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 5,289,779,803.52               | 5,235,734,641.51               |
| 391         | Газар   | 00.00                          | 00.00                          |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>   | 5,260,087,343.52               | 5,205,692,181.51               |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц  | 3,518,817,067.40               | 3,536,855,897.40               |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл   | (41,757,520.53)                | (118,236,175.14)               |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 98,379,475.24                  | 97,279,475.24                  |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл   | (50,594,502.13)                | (56,826,997.67)                |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 84,233,310.13                  | 93,515,242.33                  |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл   | (40,867,078.09)                | (45,166,652.15)                |
| 39213       | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс                                      | 1,684,787,872.55               | 1,691,182,672.55               |
| 39217       | Ном   | 7,088,718.95                   | 7,088,718.95                   |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>   | 29,692,460.00                  | 30,042,460.00                  |
| 39301       | Програм хангамж   | 770,000.00                     | 1,120,000.00                   |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл   | (770,000.00)                   | (770,000.00)                   |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө  | 29,692,460.00                  | 29,692,460.00                  |
| 39304       | Хуримтлагдсан элэгдэл   | 00.00                          | 00.00                          |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b><u>5,327,273,078.87</u></b> | <b><u>5,270,046,687.86</u></b> |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>5,327,273,078.87</u></b> | <b><u>5,270,046,687.86</u></b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 5,327,273,078.87               | 5,270,046,687.86               |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,239,669,238.14               | 1,239,669,238.14               |
| 51101       | Өмч: - төрийн   | 1,239,669,238.14               | 1,239,669,238.14               |

Монгол цэргийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

|            |  |                                |                                |
|------------|--|--------------------------------|--------------------------------|
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                            | (472,300,792.05)               | (529,527,183.06)               |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн                                     | (472,300,792.05)               | (472,300,792.05)               |
| 51220      | Тайлант үеийн үр дүн                                   | 00.00                          | (57,226,391.01)                |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                       | 4,559,904,632.78               | 4,559,904,632.78               |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН<br/>VI=IV+V</b> | <b><u>5,327,273,078.87</u></b> | <b><u>5,270,046,687.86</u></b> |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгагавар болсон тайлан /төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он              | Тайлант он            |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>291,501,450.02</b> | <b>475,170,095.00</b> |
| <b>11</b>   | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>   | <b>00.00</b>          | <b>00.00</b>          |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>96,216,950.02</b>  | <b>33,879,675.00</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 96,216,950.02         | 33,879,675.00         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 96,172,756.20         | 33,879,675.00         |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 8,421,360.00          | 9,148,600.00          |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 2,391,000.00          | 155,781.00            |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого  | 85,360,396.20         | 24,575,294.00         |
| 120009      | Бусад орлого   | 44,193.82             | 00.00                 |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>195,284,500.00</b> | <b>441,290,420.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | 195,284,500.00        | 409,420,500.00        |
